



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтай дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26 04-37, Факс: 32 32-66

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН
НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН
ЗАХИРАЛ Д.ОЮУНЦЭЦЭГ ТАНАА

2017.02.24 № 3/364
танай _____-ны № _____-г
Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Аудитаар илэрсэн дараах материаллаг дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- "Молор констракшн" ХХК-иас авах 124,8 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй,
- Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас авах цэвэр бохир усны тооцоо хийж санхүүгийн тайланд тусгаагүй, орлогыг төвлөрүүлээгүй, төвлөрүүлэх ёстой орлогыг тооцох боломжгүй,

- "Эй Би Жи Энерго" ХХК-д өгсөн 37.0 сая төгрөгийн урьдчилж гарсан зардлаар бүртгэсэн барилгын засварын ажил одоог хүртэл хийгдээгүй, тооцоо нийлээгүй
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй 84.8 сая төгрөгийн шууд авалт хийсэн
- Харьяа байгууллагын хүнсний материалын зарцуулалтын тооцоог боддоггүй, хянадаггүй
- Эдгээр нь нийт 246.6 сая төгрөгийн залруулагдах боломжгүй алдаа зөрчил байна.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитаар илэрсэн дээрх материаллаг хэмжээний зөрчлийг эс тооцвол Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

**САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг**

Утас: 261663

Цахимхаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 260512

Цахимхаяг: sambuunyamyia@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг

Утас: 260512

Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг: 3Г-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -46**

“Мишээл-Од Аудит” ХХК-ийн

Аудитынбагийнхлагч Т.Одончимэг

Утас: 99069029, 96659029

Ахлах аудитор: О.Цэндхүү

Ахлах аудитор: Б.Цогзолмаа

Аудитор Д.Дэлгэрмаа

Аудиторын туслах: М. Батмагнай

Аудиторын туслах: Э.Энхцэцэг

Утас: 99087892, 99065204

Хаяг: БГД 2 хороо Time center 601, 603

Вэб хуудас: www.misheelodaudit.mn

Цахим хаяг: misheelod@yahoo.com

2017 оны 02 дүгээр сарын 21

Аудитын тайлан

Хавсралт1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2:Аудитын тайлан

Хавсралт 3:Албан шаардлага

Хавсралт 3:Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйлэжиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитынарга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэндансны талаарх мэдээлэл:
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

НЭГ. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1дэхь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ/2017/48/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын 10-наас 2017 оны 02дугаар сарын25-ныг хүртэл хийхээр төлөвлөн багийн гишүүн “Мишээл-ОдАудит” ХХК-ийн захирал,аудитын багийн ахлагч Т.Одончимэгудирдан зохион байгуулж аудитор, туслах аудитор4 ажилтан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. /ТАБ-СТА-А-9/

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 02 дугаар сарын 15-нд “Мишээл-Од Аудит” ХХК-д ирүүлсэн байна. Завсрын үеийн аудитыг 2016 оны 10 дугаар сарын 03-наас 10 дугаар сарын 20-ны хооронд, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дугаар сарын15-наас 2017 оны 02дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь Хүүхдийн эрхийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын Ерөнхий хууль, зэрэг хуулиудын болон холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нь Монголын хүүхдийн фондын санаачилга, оролцоотойгоор 1978 онд 250 хүүхэд хүлээн авах зуны барилга байгууламжууд, 1981 онд 250 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай, өвлийн барилга тус тус ашиглалтанд орсноор бүтэн жилийн турш ажиллах боломжтойгоор байгуулагдсан байна.

Тус байгууллага нь амрагч хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, Монгол ёс заншил, уламжлал, соёлыг сэргээн хүүхэд залуучуудад өвлүүлснээр гэр бүлийн ёс зүй, харилцаа, үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрүүл аж төрөх ёсонд сургах, эх оронч сэтгэлгээтэй болгон хөгжүүлэх, амьдрах арга ухаанд сургах байгаль экологийн хүмүүжил олгох, боловсролтой, эрсдлийг даван туулах чадвартай дэлхийн иргэн болж төлөвшихөд нь дэмжлэг үзүүлэх зорилготой ажиллаж байна.

МУ-ын Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх ажлын хүрээнд Хүүхдийн төлөө газрын удирдлагын дор үйл ажиллагаагаа явуулдаг төрийн үйлчилгээний байгууллага юм. Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор нэг ээлжиндээ 600 гаруй хүүхэд хүлээн авах хүчин чадалтай нийт давхардсан тоогоор жилд 25.000 орчим хүүхэд хүлээн авахаар төлөвлөж, эрүүл мэндийн, миний гэр бүл-Миний хөгжил, Байгаль экологийн, Гадаад орчин-Эр зоригийн, Авъяасыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэдэг.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж, нэгдүгээр гарын үсгийг Даваасамбуу овогтой Оюунцэцэг, хоёрдугаар гарын үсгийг Мишигдорж овогтой Баярмаа нар зурж хөрөнгийг зарцуулж байна.

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 18 чиглэлээр 42 уламжлалт сорил, 9 хяналтын сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай танилцахад Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн “Аколоус” програмтай байна. Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Бид Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна. 2016 онд Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны дотоод аудит 2014-2016 оны үйл ажиллагаанд аудит хийсэн ба дүнг ирүүлээгүй байна

Зургаа. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төлөвлөлтийн үед орлогын төлөвлөгөөг суурь болгон авч 3,625.9 сая төгрөгийн 1.0 %-иар 36.3 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн үе шатанд гүйцэтгэлээрх орлого 2,947.5 сая төгрөгийн 1.0%-иар 29.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Тайлант онд улсын төсвөөс 1,385.7 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр санхүүжилт аваагүй, Үндсэн үйл ажиллагааны орлого 2,557.3 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 2,888.6 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 158.8 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 211.4 сая төгрөгийн орлоготой ажилласан байна. Нийт 4,101.8 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 3,100.0 сая төгрөгийн орлого төвлөрч 3,097.1 сая төгрөгийг зарцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн “Засгийн газрын агентлаг, төрийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтын талаар авах арга хэмжээний тухай” 501 дүгээр тогтоолын 9 дүгээр зүйлд зааснаар Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборыг 2016 оноос эхлэн үйл ажиллагааныхаа орлогоор өөрийгөө санхүүжүүлэх зарчимд шилжүүлж, Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны үйл ажиллагааг ажил, үйлчилгээний орлого, байгууллага, иргэний хандив, буцалтгүй тусламж, хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад эх үүсвэрээс бүрдүүлж байна гэсэн шийдвэр гаргаснаас төсвөөс 1,385.7 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн нь биелэгдээгүй байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл

2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Шилэн дансны тухай хууль батлагдан мөрдөх болсонтой холбогдуулан, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2015 оноос хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

<http://www.shilendans.gov.mn/> цахим хуудсанд байгууллагаа бүртгүүлэн байгууллагын батлагдсан төсвийг зохих маягтын дугуу оруулж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр зохих маягтын дагуу байршуулсан байна.

<http://shilendans.gov.mn/kod-017000600> /цахим хуудасны Төсвийн ил тод байдлын тухай гэсэн цэсэнд байгууллагын батлагдсан 2016 оны төсвийг байрлуулаад, 2016 оны батлагдсан бүтэц орон тоо, харилцах, кассаас зарцуулсан зарцуулалтууд, тендерийн бүх мэдээлэл, худалдан авалтууд, аудитын зөвлөмжүүдийг байршуулаад байна.

Үндэсний Аудитын газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас 2016 онд шилэн дансны гүйцэтгэлд хийсэн 2 удаагийн аудитаар зөрчил дутагдал гараагүй, зөвлөмж аваагүй байна.

Ес. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 18 чиглэлд уламжлалт болон хяналтын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр уламжлалт 42, нарийвчилсан 9, нийт 51 горим, сорил гүйцэтгэв. Гүйцэтгэсэн сорилын үр дүнгээс харахад тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд материаллаг хэмжээний зөрчлүүд илэрсэн бөгөөд үйл ажиллагааны үр дүн хангалттай сайн байсангүй гэж бид үзсэн болно.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт ажил гүйлгээг 70,0 орчим хувь хамарсан байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг дараах алдаа зөрчил илэрсэн.Үүнд:

1. 2016 оны 10 сарын байдлаар иргэн, аж ауйн нэгж байгууллагаас нийт 27.3 сая төгрөгийн байр ашиглалтын төлбөрийг авлагаар хүлээн зөвшөөрч, бүртгэлд тусгаагүй, ажилчдын цалингаас суутгасан орон сууцны хөлс, хоолны мөнгө 16.2 сая төгрөгийг гцалингийн зардлыг бууруулан, орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтөлнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар зөвлөмж хүргүүлж, жилийн эцсийн санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

2. Тус цогцолбор нь өөрийн болон эргэн тойронд байрлах Аж ахуйн нэгж болон айл өрхөөс цэвэр, бохир усны төлбөрийг нийт дүнгээр холбогдох байгууллагад шилжүүлдэг байна. Гэтэл зарим харилцагчийн өмнөөс төлсөн төлбөрийг буцаан төвлөрүүлээгүй, тооцоо хийгээгүй, хэдэн төгрөг авах нь тодорхойгүй данс бүртгэлд тусгаагүйбайгаа нь “Ажилчдын орон сууцны үнэ тариф” баталсан Найрамдал цогцолборын захирлын 2013 оны 11 тоот тушаалыг зөрчсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харилцагчаас авах цэвэр бохир усны тооцоог хийн санхүүгийн тайланд тусгах, орлогыг төвлөрүүлэх зөвлөмж хүргүүлэв.

3. Тус цогцолборын харъяа “Марал” зочид буудлын ор хоног, хоолны тооцоог огт боддоггүй түүнд тавих хяналт байхгүй байна. Энэ нь УСНББОУС-9-19-д заасан “Үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадах тохиолдолд тайлангийн өдрийн ажил гүйлгээний иж бүрдэлтийн

үе шатыг харгалзан уг ажил гүйлгээтэй холбогдох орлогыг хүлээн зөвшөөрөх гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зочид буудлын ор хоног хоолны тооцоог хийж, хяналт тавин ажиллах зөвлөмж хүргүүлэв.

4. “Молор констракшн” ХХК-иас авах 143 айлын орон сууцны 2014 оноос хойш үүссэн ашиглалтын зардлын 124.8 сая төгрөгийн авлагыг данс бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний дагуу “Молор констракшн” ХХК-иас авах авлагыг баталгаажуулах талаар албан шаардлага хүргүүлэх.

5. “Эй Би Жи Энерго” ХХК-тай барилгын засварын ажил гүйцэтгүүлэхээр 37.0 сая төгрөг шилжүүлсэн боловч засварын ажил хийгдээгүй байна. Мөн “Сити эйр Майлс” ХХК-д урьдчилж гарсан зардлаар 0.6 сая төгрөг тус тус шилжүүлэн өгсөн нь үндэслэлгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Эй Би Жи Энерго” ХХК-иас 37.0 сая төгрөг, “Сити эйр Майлс” ХХК –иас 0.6 сая төгрөгийг гаргуулан авах талаар албан шаардлага хүргүүлэх

6. Ажилтан, албан хаагчдад олгож буй цалин хөлс нь цалингийн сүлжээтэй тохирохгүй, алслагдсан газрын нэмэгдэл гэсэн нэртэйгээр цалинг нэмэгдүүлэн олгож байгаа нь “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10-р сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэв.

7. Тус байгууллагын 2016 оны 12 дугаар сарын хүнсний материалын зарцуулалтанд нарийвчилсан горим гүйцэтгэхэд 143.1 сая төгрөгийн зарцуулалтыг байгууллагын удирдлага, санхүүгийн алба хянаагүй, тооцоог бодоогүй байлаа. Мөн зургаан өдрийн хүнсний материалын зарцуулалтыг технологийн карттай тулган шалгахад материалын 60.0 орчим хувь нь нормоос илүүдэх, дутах байдлаар зөрүүтэй байгаа зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэхь заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн

хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр буюу цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэв.

Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Анхны өртгөө элэгдлээрээ нөхөж 0 үлдэгдэлтэй болсон 6,721.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна. Энэ нь УСНББОУС-17-49-д “хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалтыг зөрчсөн байна. Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 297 тогтоолоор Засгийн газрын 2005 оны “Журам батлах тухай” /Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох/ 233 дугаар тогтоолыг хүчингүй болгосон байтал, хүчингүй болсон дээрх тогтоолоор элэгдэл тооцсон хэвээр байна.

Шийдвэрлэсэн нь:Зөвлөмж хүргүүлэв.

2. Тус байгууллага нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан заавар журамд нийцүүлэн боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэв.

3. Харшийн сүлд модны наадамд оролцсон хүүхдүүдэд зориулан 84.8 сая төгрөгийн бэлэг худалдан авсан байна.Уг худалдан авалтыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ, гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Зөвлөмж хүргүүлэв

4. Харшийн сүлд модны наадмын үеэр 31 бэлгийг худалдан борлуулсны орлого 558.0 мянган төгрөг, жилийн эцсийн тооллогоор дуу хөгжмийн багш Б.Мөнхтэнгэрийн дутагдуулсан 1,759.9 мянган төгрөгийн үнэтэй CD тоглуулагчийн төлбөр 331.9 мянган төгрөгийг касст орлого аваагүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа /бусад орлого/-аас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг/түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн

өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртэлийн дансанд тушаана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:Зөвлөмж хүргүүлэв.

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад материаллаг бус залруулагдаагүй гурван зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгөх болно.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг баталгаажуулахаар аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгасан ба дараагийн аудитаар 2016 онд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хянахаас гадна 2017 оны хүнсний материалын худалдан авалт болон тендер шалгаруулалтыг хуулийн дагуу байгууллагад үр ашигтай байдлаар зохион байгуулсан эсэхийг үзэх болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын явцад материаллаг хэмжээний нийт 7,155.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 162.4 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 6,993.0 төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв. Үүнээс анхны өртгөө элэгдлээрээ нөхөж 0 үлдэгдэлтэй болсон 6,721.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчлийг материаллаг бус гэж үзлээ.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж 69.0 сая төгрөгийн авлага барагдуулах албан шаардлага өгснийг барагдуулсан, 4 зөвлөмж өгснөөс 3 нь биелж, 1 зөвлөмж биелээгүй байна. Бид 2016 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар 6,178.8 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсний биелэлтийг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захирлын 2017 оны 117 тоот албан бичгээр ирүүлснийг тайланд хавсаргасан болно.

Арван зургаа.Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитаар илэрсэн дээрх материаллаг хэмжээний зөрчлийг эс тооцвол Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитын санхүүгийн тайлан 10 хуудастай.



ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512
Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn
Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 260512
Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -46**

**“Мишээл-Од Аудит” ХХК-ийн
Аудитын багийн ахлагч Т.Одончимэг**
Утас: 99069029, 96659029
Ахлах аудитор: О.Цэндхүү
Ахлах аудитор: Б.Цогзолмаа
Аудитор Д.Дэлгэрмаа
Аудиторын туслах: М. Батмагнай
Аудиторын туслах: Э.Энхцэцэг
Утас: 99087892, 99065204
Хаяг: БГД 2 хороо Time center 601, 603
Вэб хуудас: www.misheelodaudit.mn
Цахим хаяг: misheelod@yahoo.com

Тэргүүлэх ач холбогдол № 1 зүйлс:

Асуудал 1
Орлогын бүртгэлийн талаар3

Асуудал 2
Цалин хөлсний бүртгэлийн талаар.....4

Асуудал 3
Хүнсний материалын зарцуулалтын талаар..5

Тэргүүлэх ач холбогдол № 2 зүйлс:

Асуудал 4
Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаар.....6

Асуудал 5
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт
Бичгийн талаар.....7

Асуудал 6
Худалдан авалтын талаар.....8

Асуудал 7
Орлого тушаагаагүй талаар.....9



2017 оны 02 дугаар сар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын захиралд зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай компанийн үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Тус цогцолбор нь өөрийн болон эргэн тойронд байрлах Аж ахуйн нэгж болон айл өрхөөс цэвэр, бохир усны төлбөрийг нийт дүнгээр холбогдох байгууллагад шилжүүлдэг байна. Гэтэл зарим харилцагчийн өмнөөс төлсөн төлбөрийг буцаан төвлөрүүлээгүй, тооцоо хийгээгүй, хэдэн төгрөг авах нь тодорхойгүй данс бүртгэлд тусгаагүй байгаа нь “Ажилчдын орон сууцны үнэ тариф” баталсан Найрамдал цогцолборын захирлын 2013 оны 11 тоот тушаалыг зөрчсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д “Эд хөрөнгийн төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тус цогцолборын харъяа “Марал” зочид буудлын ор хоног, хоолны тооцоог огт боддоггүй түүнд тавих хяналт байхгүй байна. Энэ нь УСНББОУС-9-19-д заасан “Үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон ажил гүйлгээний үр дүнг найдвартай тооцоолж чадах тохиолдолд тайлангийн өдрийн ажил гүйлгээний иж бүрдэлтийн үе шатыг харгалзан уг ажил гүйлгээтэй холбогдох орлогыг хүлээн зөвшөөрөх гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Эрсдэлүүд

1. Санхүүгийн тайланг УСНББОУС-9 Орлогын бүртгэлийн стандартын дагуу бүртгэгдэхгүй байх /ИБ, ОБ, ЭҮ, ТИ/
2. Өөрийн орлогыг өдөр тутам бүртгээгүй байх, дутуу бүртгэсэн байх

ҮАГ-ын зөвлөмжүүд

1. УСУГ болон оршин суугчидтай халуун ус, цэвэр, бохир усны тооцоог нөхөн хийх
2. Буудлын болон хоол үйлдвэрлэлийн орлогод хяналт тавих журам гаргаж, тооцоо бодох, орлого хураалтыг цахимжуулах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Ажилтан, албан хаагчдад олгож буй цалин хөлс нь цалингийн сүлжээтэй тохирохгүй, алслагдсан газрын нэмэгдэл гэсэн нэртэйгээр цалинг нэмэгдүүлэн олгож байгаа нь “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10-р сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолыг зөрчиж байна.

Эрсдэлүүд

1. Цалингийн нэмэгдлүүдийг буруу тооцоолох/ТБ,Х,ЭҮ,ҮЗ/
2. Хууль тогтоомж, заавар журмыг мөрдөөгүй байх. /ЭҮ,ТБ, ИБ,Х/

ҮАГ-ын зөвлөмж

“Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2014 оны 10-р сарын 11-ний өдрийн 332 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллагын 2016 оны 12 дугаар сарын хүнсний материалын зарцуулалтанд нарийвчилсан горим гүйцэтгэхэд 143.1 сая төгрөгийн зарцуулалтыг байгууллагын удирдлага, санхүүгийн алба хянаагүй, тооцоог бодоогүй байлаа. Мөн зургаан өдрийн хүнсний материалын зарцуулалтыг технологийн карттай тулган шалгахад материалын 60.0 орчим хувь нь нормоос илүүдэх, дутах байдлаар зөрүүтэй байгаа зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэхь заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр буюу цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтыг зөрчиж байна.

Эрсдэлүүд

1. Баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан байх
2. Холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4-д "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх", мөн хуулийн 13.4 дэхь заалт "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр буюу цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудыг мөрдөж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Анхны өртгөө элэгдлээрээ нөхөж 0 үлдэгдэлтэй болсон 6,721.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна. Энэ нь УСНББОУС-17-49-д “хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалтыг зөрчсөн байна. Засгийн газрын 2014 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 297 тогтоолоор Засгийн газрын 2005 оны “Журам батлах тухай” /Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцох/ 233 дугаар тогтоолыг хүчингүй болгосон байтал, хүчингүй болсон дээрх тогтоолоор элэгдэл тооцсон хэвээр байна.

Эрсдэлүүд

1. Элэгдэл нь дууссан үндсэн хөрөнгийн их хэмжээний үлдэгдлийг актлахгүй байх
2. Холбогдох стандартын заалтыг зөрчсөн байх

ҮАГ-ын зөвлөмж

6,721.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг УСНББОУС-17-19-д заасны дагуу дахин үнэлэж ашиглалтын хугацааны элэгдлийг тооцох талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт асуудал тавьж шийдвэрлүүлэх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

Асуудал 5: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар

**Тэргүүлэх ач холбогдол
№2**

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь УСНББОУС болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан заавар журамд нийцүүлэн боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

1. Төсвийн байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичиг УСННБОУС-тай нийцээгүй байх
2. Холбогдох хууль, журам, стандартын заалтыг зөрчсөн байх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан, баталж, мөрдөж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Харшийн сүлд модны наадамд оролцсон хүүхдүүдэд зориулан 84.8 сая төгрөгийн бэлэг худалдан авсан байна. Уг худалдан авалтыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт хийсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ, гэсэн заалттай нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

1. Худалдан авалт хийхдээ холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчсөн байх

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг мөрдөж ажиллах, Цаашид байгууллагыг үр ашиггүй ажиллуулах, үргүй зарцуулалт гаргахгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Харшийн сүлд модны наадмын үеэр 31 бэлгийг худалдан борлуулсны орлого 558.0 мянган төгрөг, жилийн эцсийн тооллогоор дуу хөгжмийн багш Б.Мөнхтэнгэрийн дутагдуулсан 1,759.9 мянган төгрөгийн үнэтэй CD тоглуулагчийн төлбөр 331.9 мянган төгрөгийг касст орлого аваагүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан Мөнгөн кассын ажиллагааны журмын 2.6-д “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа /бусад орлого/-аас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг/түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй/ ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртэлийн дансанд тушаана” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажилаагүй байна.

Эрсдэлүүд

1. Санхүүгийн тайланг УСНББОУС-9 Орлогын бүртгэлийн стандартын дагуу бүртгэгдэхгүй байх /ИБ, ОБ, ЭҮ/
2. Өөрийн орлогыг өдөр тутам бүртгээгүй байх, дутуу бүртгэсэн байх

ҮАГ-ын зөвлөмж

889,9 мянган төгрөгийг касст орлого авч, бүртгэлд тусгах, орлогыг тушаагаагүй албан тушаалтанд хариуцлага тооцох

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАИРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН АУДИТ ХИЙГДСЭН

2016 II Ү АЖИЛЛАХ ҮНЭТ

НАЙ О АЖИЛ АЖИЛАХ ҮНЭТ

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

ᠰᠡᠵᠡᠭᠡᠳᠡ	Аудитаар баталгаажсан үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	2,966,040.20
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	1,616,300.00
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	-	1,349,740.20
АВЛАГА	135,346,479.70	29,706,681.07
Бусад авлага	135,346,479.70	29,706,681.07
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР	10,609,000.00	37,609,000.00
Урьдчилж гарсан зардал	10,609,000.00	37,609,000.00
БАРАА МАТЕРИАЛ	458,457,756.48	378,190,564.47
Түүхий эд материал	378,360.00	408,200.00
Хангамжийн материал	458,079,396.48	377,782,364.47
Түлш, шатах тослох материал	-	-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	604,413,236.18	448,472,285.74
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,632,891,418.26	7,172,035,938.89
Биет хөрөнгө	7,625,752,110.31	7,167,452,397.38
Барилга байгууламж	15,784,029,346.00	15,784,029,346.00
Хуримтлагдсан элэгдэл	(9,740,504,989.79)	(9,929,939,818.91)
Авто тээврийн хэрэгсэл	532,597,446.70	532,597,446.70
Хуримтлагдсан элэгдэл	(235,842,091.49)	(309,241,307.97)
Машин, тоног төхөөрөмж	1,614,394,708.09	1,622,144,598.09
Хуримтлагдсан элэгдэл	(669,615,830.51)	(816,551,868.89)
Тавилга, аж ахуйн эд хогшил	633,926,311.97	633,926,311.97
Хуримтлагдсан элэгдэл	(405,660,608.09)	(441,500,967.06)
Бусад үндсэн хөрөнгө	554,328,188.53	554,328,188.53
Хуримтлагдсан элэгдэл	(441,900,371.10)	(462,339,531.08)
Биет бус хөрөнгө	7,139,307.95	4,583,541.51
Програм хангамж	8,692,044.00	8,692,044.00
Хасагдуулга	(5,552,735.97)	(7,608,502.37)
Бусад	5,000,000.00	5,000,000.00
Хасагдуулга	(1,000,000.08)	- 1,500,000.12
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,632,891,418.26	7,172,035,938.89
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,237,304,654.44	7,620,508,224.63
Богино хугацаат өр төлбөр	2,738,820.00	348,092,390.66
Өглөг	2,738,820.00	348,092,390.66
Ажиллагчидтай холбогдсон өглөг	-	101,587,897.29
Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	237,193,640.37
Бусад өглөг	2,738,820.00	9,310,853.00
Урьдчилж орсон орлого	-	41,797,450.00
Урьдчилгаа төсвийн татаас	-	41,797,450.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,738,820.00	389,889,840.66
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	2,738,820.00	389,889,840.66
Засгийн газрын оруулсан капитал	6,063,454,256.84	6,063,454,256.84
Өмнөх үеийн үр дүн	(1,480,976,919.45)	(1,480,343,478.79)
Тайлант үеийн үр дүн	-	(1,004,580,891.13)
Дахин үнэлгээний зөрүү	3,652,088,497.02	3,652,088,497.02
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	8,234,565,834.41	7,230,618,383.94
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	8,237,304,654.41	7,620,508,224.60

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 Í Í Õ ÆËËËËÍ ÝÕÑËËÍ
САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Аудитаар баталгаажсан дүн	
	Өмнөх он	Тайлант он
		-
Улсын төсвөөс	753,257,807.01	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	120,790,116.00	-
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авах авлага	50,000,000.00	-
ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах	6,901,500.00	
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	30,000,000.00	
Төсвийн урамшуулал	33,888,616.00	
Бараа үйлчилгээний орлого	162,377,147.08	166,151,717.58
Төрийн өмч түрээслүүлсний орлого	3,581,900.00	1,000,000.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	158,795,247.08	165,151,717.58
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	2,467,571,293.25	2,781,357,536.85
Үндсэн үйл ажиллагааны орлого	2,465,201,293.25	2,781,357,536.85
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,370,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,503,996,363.34	2,947,509,254.43
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,880,902,590.36	3,932,546,145.56
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	1,492,164,359.56	1,411,897,710.50
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,346,698,962.66	1,271,740,719.07
Цалин	1,157,493,462.66	1,255,924,754.07
Унаа хоолны хөнгөлөлт	118,998,000.00	11,415,965.00
Гэрээтийн цалин	70,207,500.00	4,400,000.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	145,465,396.90	140,156,991.43
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	53,398,835.90	49,612,230.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	92,066,561.00	90,544,761.43
Тогтмол зардал	490,611,532.98	554,674,193.79
Гэрэл цахилгааны зардал	190,985,866.79	200,311,754.50
Түлш, халаалтын зардал	162,345,719.96	194,079,396.26
Цэвэр, бохир усны зардал	137,279,946.23	160,283,043.03
Хангамж, бараа материалын зардал	192,200,191.02	228,171,128.44
Бичиг хэргийн материал	9,339,807.60	9,799,328.68
Тээвэр, шатахууны зардал	100,969,200.00	129,739,100.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	7,158,569.19	7,085,405.64
Ном, хэвлэлийн зардал	1,026,800.00	-
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	70,601,706.23	78,802,415.12
Бараа материал акталсны зардал	3,104,108.00	2,744,879.00
Нормативт зардал	1,015,718,872.21	1,050,964,202.41
Эм	1,947,780.00	1,820,160.00
Хоол	1,001,627,669.71	1,015,860,234.41
Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,143,422.50	33,283,808.00
Эд хогшил, урсгал засварын зардал	117,899,262.85	111,731,890.85
Урсгал засвар	107,662,466.85	110,462,100.85
Багаж хэрэгсэл	7,160,416.00	
Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл	3,076,380.00	1,269,790.00
Томилолт, зочны зардал	3,963,320.00	18,200,277.00
Гадаад томилолтын зардал	977,920.00	15,799,277.00
Дотоод томилолтын зардал	1,884,000.00	2,000,000.00
Гадаад зочны зардал	1,101,400.00	401,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	6,001,035.00	36,728,479.13
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	1,162,500.00	24,290,672.13
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал		5,110,020.00

Даатгалын үйлчилгээний төлбөр	1,323,535.00	2,604,410.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,440,000.00	1,214,400.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	245,000.00	205,500.00
Мэдээлэлийн технологийн үйлчилгээний хөлс	1,830,000.00	3,060,080.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хөлс		243,397.00
Бараа үйлчилгээний бусад зардал	562,344,016.74	520,178,263.44
Бусад зардал	40,050,083.70	15,924,100.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	32,946,966.97	35,648,794.07
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	489,346,966.07	468,605,369.37
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,832,517.00	19,544,000.00
Бусад урсгал шилжүүлэг	48,832,517.00	19,544,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,007,198.00	150,000.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,234,200.00	-
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	26,591,119.00	19,394,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,929,735,107.36	3,952,090,145.56
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(425,738,744.02)	(1,004,580,891.13)
Үндсэн хөрөнгө бараа материал худалдсаны олз	300,000.00	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	300,000.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	64,986,985.80	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	64,986,985.80	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(490,425,729.82)	(1,004,580,891.13)

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН АУДИТ ХИЙГДСЭН

2016 11 0 АЭЭЭЭЭЙ ҮӨНЭЭЙ

а 1 хЭЭЙ а а ДхЭа ЭӨЭЭЙ 0АЭЭАЙ

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	6,063,454,256.84	3,652,088,497.02	-990,551,189.63	0.00	8,724,991,564.23
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,063,454,256.84	3,652,088,497.02	-990,551,189.63	0.00	8,724,991,564.23
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өлз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-490,425,729.82	0.00	-490,425,729.82
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,063,454,256.84	3,652,088,497.02	-1,480,976,919.45	0.00	8,234,565,834.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	633,440.66	0.00	633,440.66
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,063,454,256.84	3,652,088,497.02	-1,480,343,478.79	0.00	8,235,199,275.07
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй өлз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-1,004,580,891.13	0.00	-1,004,580,891.13
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	6,063,454,256.84	3,652,088,497.02	-2,484,924,369.92	0.00	7,230,618,383.94

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН НАЙРАМДАЛ ЦОГЦОЛБОРЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 Í Í Ò ÆÈÈÈÍ ÝÕÈÈÍ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

ᠮᠣᠩᠭᠡᠨ ᠭᠦᠢᠯᠭᠡᠨᠢ	Аудитаар баталгаажсан дүн	
	Өмнөх он	Тайлант он
Тусламж, санхүүжилтын орлого	874,047,923.01	-
Улсын төсвөөс	753,257,807.01	-
Урсгал	753,257,807.01	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	120,790,116.00	-
Төрийн болон орон нутгийн өмч бус этгээдээс авах авлага	50,000,000.00	-
ЗГНХ Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах	6,901,500.00	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	30,000,000.00	-
Төсвийн урамшуулал	33,888,616.00	-
Бараа, үйлчилгээний орлого	2,503,032,302.83	3,100,020,448.07
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	2,503,032,302.83	3,100,020,448.07
Үндсэн үйл ажиллагааны орлого	2,340,663,802.83	2,888,642,836.85
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	158,786,600.00	210,377,611.22
Төрийн өмч түрээслүүлсэний орлого	3,581,900.00	1,000,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,377,080,225.84	3,100,020,448.07
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,335,703,427.84	3,068,955,017.87
Ажиллагчидтай холбогдсон зардал	1,493,571,299.76	1,250,801,024.65
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,345,538,299.77	1,150,939,566.02
Цалин	1,156,332,799.77	1,139,523,601.02
Унаа хоолны хөнгөлөлт	118,998,000.00	11,415,965.00
Гэрээтийн цалин	70,207,500.00	-
Ажил олгогчоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	148,032,999.99	99,861,458.63
Тэтгэврийн даатгалын шимтгэл	94,634,164.09	64,919,732.63
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	10,766,036.36	4,695,063.00
ҮОМШ өмчийн даатгалын шимтгэл	13,457,545.45	8,956,259.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,691,509.09	4,236,576.00
ЭМД-н хураамж	26,483,745.00	17,053,828.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	1,842,132,128.08	1,818,153,993.22
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	527,290,599.12	466,291,553.08
Гэрэл цахилгааны зардал	190,985,866.79	188,125,278.13
Түлш, халаалтын зардал	199,024,786.10	117,883,231.92
Цэвэр, бохир усны зардал	137,279,946.23	160,283,043.03
Хангамж, бараа материалын зардал	178,297,560.19	160,396,993.64
Бичиг хэрэг	10,041,168.00	5,750,070.00
Тээвэр, шатахуун	110,556,200.00	76,901,900.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,158,569.19	7,093,405.64
Ном, хэвлэл	1,026,800.00	200,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	49,514,823.00	70,451,618.00
Нормативт зардал	941,580,226.77	948,602,609.50
Эм бэлдмэл эмнэлэгийн хэрэгсэл	2,075,000.00	2,488,000.00
Хоол хүнс	916,823,926.77	935,238,569.50

Нормын хувцас зөөлөн эдлэл	22,681,300.00	10,876,040.00
Эд хогшил, урсгал засварын зардал	106,715,843.00	113,877,385.00
Багаж техник хэрэгсэл	10,428,780.00	6,225,640.00
Тавилга	-	660,000.00
Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	3,245,620.00	-
Урсгал засвар	93,041,443.00	106,991,745.00
Томилолт, зочны зардал	3,963,320.00	23,811,341.00
Гадаад албан томилолт	977,920.00	20,471,341.00
Дотоод албан томилолт	1,884,000.00	2,000,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	1,101,400.00	1,340,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,001,035.00	30,129,657.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураа	1,162,500.00	20,058,950.00
Аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	3,725,000.00
Даатгалын үйлчилгээ	1,323,535.00	2,604,410.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,440,000.00	1,214,400.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	245,000.00	205,500.00
Мэдээлэл технологийн үйлчилгээ	1,830,000.00	2,078,000.00
Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хуримтлагдсан ашиг	-	243,397.00
Бараа үйлчилгээний бусад зардал	78,285,042.00	75,044,454.00
Бараа үйлчилгээний бусад зардал	41,376,798.00	46,455,640.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	36,908,244.00	28,588,814.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,376,798.00	20,349,500.00
Бусад урсгал шилжүүлэг	41,376,798.00	20,349,500.00
Ажил олгочоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,007,198.00	150,000.00
Тэтгэвэрт гархад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	8,234,200.00	-
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	19,135,400.00	20,199,500.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	3,377,080,225.84	3,089,304,517.87
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-	10,715,930.20
Хөрөнгийн орлого	-	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	7,749,890.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	7,749,890.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	7,749,890.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(7,749,890.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Засгийн газрын бондын үндсэн төлбөр	-	-
Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	2,966,040.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	2,966,040.20